

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АСУУДАЛ

ISSUES ON PROVIDING THE BAILIFF SAFETY OF EXECUTIVE AGENCIES OF COURT DECISION



Ч.ЦЭНГЭЛБАЯР Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч

TSENGELBAYAR CH. Senior specialist of the Department of Safety, General Executive Agency of Court Decision, major

Товч агуулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдал гэдэг нь “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар цагдан хорих, баривчлах, хорих ял эдлүүлэх, иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд холбогдох албан тушаалтан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор бүрэн хангагдсан байхыг хэлнэ.

Abstract: Bailiff safety of Executive agencies of Court decision is according to law on court decision execution: “ Executive officers who deal with law detention, arresting, putting in jail and executing or implementing the obligations related to civil and administrative court’s decision must to be provided with the safety”.

Аюулгүй байдал гэдэг нь судалгааны түвшнөөсөө хамааран харилцан адилгүй бүтэцтэй учраас нарийн тодорхойлоход хүндрэлтэй байдаг бөгөөд ихэнхи судлаачид аюулгүй байдал гэдгийг түрэмгийллээс / гадаад улсын/ ангид байхаар хязгаарлаж ойлгодог. Харин Ричард Уллман аюулгүй байдлыг дан ганц цэргийн аюул заналаар хязгаарлах нь бодит байдалтай нийцэхгүй гэж үзсэн. Тэрээр «Ард иргэдийн амьдралын түвшинг богино хугацаанд бууруулах аюултай нөхцөл байдал үүсэх, эсвэл төрийн болон төрийн бус байгууллагуудын баримтлах бодлого тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ мэдэгдэхүйц хязгаарлагдсан нөхцөлд аюулгүй байдал алдагдах эрсдэл үүснэ» хэмээн тодорхойлсон байна. Аюулгүй байдлын талаар улс бүр өөр өөрийн ойлголттой байх тул тухайн орны соёлын онцлогыг мөн харгалзаж үзэх хэрэгтэй.

Аюулгүй байдлын цөмд хэн оршиж байгаагаас нь хамаарч, түүнийг “төр төвтэй”, “хүн төвтэй” гэж 2 ангилж болох юм. Төр төвтэй аюулгүй байдлын тухай ойлголт нь: хүнийг, төрийн оршин тогтнох нэг хэрэгсэл гэж үзэж төрийн аюулгүй байдлыг иргэний аюулгүй байдлаас дээгүүрт тавьдаг.

Тэгвэл хүн төвтэй аюулгүй байдал гэдэг нь: төрийг, иргэнд үйлчилдэг механизм гэж үзэж иргэний аюулгүй байдлыг хангаснаар төрийн аюулгүй байдал

хангагдана гэж үздэг байна.

Анх төр үүссэн учир шалтгаан, эрх зүйт, ардчилсан нийгмийн үндсэн зарчим зэргийг анхаарч үзвэл, “иргэн төвтэй аюулгүй байдал”-ийн тухай ойлголт нь илүү хүлээн зөвшөөрөгдөхүйц юм.

Аж үйлдвэрийн хувьсгалын дараагаар аюулгүй байдлын салбарт “хөдөлмөрийн хуваарь”, “мэргэших” хандлага бий болж, улмаар “гадаад аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал” гэж 2 хуваагдах болсон. Аюулгүй байдлын салбарын “гадаад аюулгүй байдал” буюу “хамгаалалт”/defence/ хэмээн нэрлэгдэж буй хэсэгт үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд “зэвсэгт хүчин” (armed forces) хэмээгддэг бол “дотоод аюулгүй байдал”-ын салбарт үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд “аюулгүй байдлын үйлчилгээ” (correctional service -law enforcement agencies) гэгддэг байна.

Өнгөц харахад адилхан дүрэмт хувцас өмсдөг, зэвсэг агсдаг зэргээрээ адилхан юм шиг харагдаж болох ч дээрх хоёр мэргэжлийн хүмүүсийн үйл ажиллагааны агуулга, хэрэглэж буй зэвсгийн хэмжээ, хүчин чадал нь огт өөр юм.

Дайн хийх, дайсан, устгах зэрэг нь зэвсэгт хүчинтэй холбоотой ойлголт байдаг. Өөрөөр хэлбэл зэвсэгт хүчний эсрэг талд дайсан байж, түүнийг устгахын тулд дайн хийдэг бол цагдаагийн байгууллага нь хууль сахиулах үүргээ гүйцэтгэх (үйлчилгээ үзүүлэх)-

дээ дайсантай бус иргэнтэй харилцаж, зорилго нь түүнийг устгах бус аюулгүй болгох байдаг. Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх талбар нь цэргийн (military) шинжтэй байдаг бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүрэг гүйцэтгэж буй талбар нь эрүүгийн (prison) шинжтэй байдаг бөгөөд болзошгүй дотоод аюулгүй байдлын асуудлаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохын тулд зэвсэгт хүчнээ зузаатгана гэхээсээ илүү шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаа шаардлагатай хүн хүч, техник хэрэгслээр хангах нь илүү оновчтой алхам байх юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдал гэдгийг Хяналт шалгалт, дотоод аудит, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам"-д "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаар цагдан хорих, баривчлах, хорих ял эдлүүлэх, иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд холбогдох албан тушаалтан эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөл боломжоор бүрэн хангагдсан байхыг хэлнэ" гээд албан хаагчийн аюулгүй байдлыг хангах гэдгийг "гүйцэтгэж байгаа албан үүрэгтэй нь холбогдуулан бусад албан хаагч болон сэжигтэн, яллагдагч, ялтан, түүний ар гэр, найз нөхөд, төлбөр төлөгч, төлбөр авагч, гуравдагч этгээдийн зүгээс аливаа хэлбэрээр дарамтлах, хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагчийг хуульд зааснаар урьдчилан сэргийлэх, хамгаалахыг ойлгоно". гэж тус тус тодорхойлсон байдаг.


Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2012 онд ШШГЕГ-ын харьяа Улаанбаатар хотын бүсийн төвлөрсөн хорих ангийн эмэгтэй албан хаагчдаас судалгаа авсан байна.

Уг санал асуулгад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эмэгтэй албан хаагчдын ихэнх хувь буюу 67 хувь нь шууд ялтан, хоригдолтой харьцаж ажилладаг болохыг дурьдаад эмэгтэй албан хаагчид ялтан, хоригдогчтой ажиллах үед ялтан, хоригдогчийн зүгээс хэл амаар доромжлох, биед халдах асуудлууд гардаг талаар энэхүү санал асуулгад тусгажээ.

Мөн 2013 онд анги алба нэгжээс албан үүргээ гүйцэтгэх үед нь эрх чөлөөнд халдсан, гэмт хэрэг, халдлагад өртсөн албан хаагчдын судалгаанаас үзэхэд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хэл амаар доромжлох, заналхийлэх, биед нь халдах хүнд, хөнгөн гэмтэл учруулах улмаар амь насыг нь хохироох явдал гарч энэ байдал таслан зогсоогдохгүй байгаа бөгөөд албан хаагчдын аюулгүй байдлыг хангах нь нэн түрүүнд онцлон хөндөх чухал асуудал болж байгааг анхаарч Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, 231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох зэрэг зүйлүүдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж бусдад анхааруулга, сургамж болгох хэрэгтэй.

Анги алба нэгжээс албан үүргээ гүйцэтгэх үед нь эрх чөлөөнд халдсан, гэмт хэрэг, халдлагад өртсөн явдлыг анги албадын шийдвэрлэсэн байдлыг авч үзэхэд тухайн ялтныг өөр хорих ангид шилжүүлсэн, дэглэм дээшлүүлэх байдлаар шийдвэрлэсэн, эсвэл ямар нэгэн арга хэмжээ аваагүй, нөгөө талаар албан хаагч өөрийн аюулгүй байдлыг хангуулах талаар арга хэмжээ аваагүй байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны 12 сарын 30 өдрийн А/242 тоот тушаалаар батлагдсан "Хяналт шалгалт, дотоод аудит, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам"-д Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлийг дараах чиглэлд томъёолсон байдаг үүнд:

1. Байгууллагын аюулгүй байдал;
2. Албан хаагчийн аюулгүй байдал;
3. Сэжигтэн, яллагдагч, ялтны аюулгүй байдал;
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал;
5. Хүнс,эрүүл ахуйн аюулгүй байдал;
6. Мэдээлэл, техник, технологийн аюулгүй байдал;
7. Санхүү, төсвийн хөрөнгийн аюулгүй байдал;
8. Галт зэвсэг, тусгай хэрэгслийн аюулгүй байдал;
9. Байгууллагын барилга байгууламжийн аюулгүй байдал зэрэг болно.

ТООН ҮЗҮҮЛЭЛТ



Хэдийгээр ингэж аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны чиглэлийг томъёолсон боловч хэрхэн хангах талаар болон нарийвчлан тодорхойлоогүй бөгөөд аюулгүй байдлыг хамрах хүрээ нь албан хаагчдын хувьд ажлын зохион байгуулалт, ажлын байрны тодорхойлолт, албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүйн байдал, ажлын ачаалал, хөтөлдөг бүртгэл, судалгаа, мэдээ, тайлан, албан бичгийн хөтлөлт, архивын үйл ажиллагаа, иргэд, байгууллага, албан хаагчдаас гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, албан хаагчдын дунд зохион байгуулсан сургалт, албаны бэлэн байдал зэрэг байна.

Албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь албаны аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, түүний объектуудыг аюул заналаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа эрх зүй, нийгэм, эдийн засаг, хөдөлмөр-зохион байгуулалт, оюун санаа, эмнэлэг, экологи, захиргааны арга хэмжээний нэгдсэн тогтолцоо бөгөөд эдгээрийг оновчтой бүрдүүлэх явдал юм.

Нийгмийн хүрээнд хөдөлмөрийн үнэлэмж, үнэлгээ, нэр хүндийг өндөржүүлснээр албан хаагчдын аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой. Албан хаагчдын аюулгүй байдал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдлын илэрхийлэл, тавигдсан үүргийг амжилттай гүйцэтгэхийн угтвар нөхцөл болж өгдөг.

Нийгэм-эдийн засгийн хангалт нь алба хаагчдын нийгмийн хамгаалалтыг хангаж буй цогц арга хэмжээний тогтолцоо бөгөөд ШШГБайгууллагын өнөөгийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан, улсын эдийн засгийн чадамжийг ухаалаг хослуулсан зардал, санхүүжилт хийх, хууль тогтоомжоор олгогдсон нийгмийн хамгаалал, халамж, хөнгөлөлтийг эдлүүлэх, алба хаагчдыг төрөл бүрийн даатгалд хамруулах, алба хаагчдын материал хэрэгсэл, хүнс, хувцас, түүний чанар, хангалт шаардлагын түвшинд тасралтгүй байх, түүнчлэн цалин хөлс, эрүүл мэнд, боловсрол, мэргэжил олголт, чөлөөт цаг, офицер ахлагч нарын гэр бүлийн хүмүүсийн нийгмийн хамгаалал, соёл, ахуй үйлчилгээ, цэргийн албан хаагчийн нэр төрийг хамгаалах зэрэгт анхаарах шаардлагатай юм.

Манай хөрш ОХУ, БНХАУ-д нийгмийн болон эрх зүйн баталгааг хуулиар баталгаажуулан, төсөл хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, ялангуяа бүтцийн өөрчлөлт, бэлтгэлээр цэргийн албанаас халагдаж байгаа цэргийн албан хаагчид, тэдний гэр бүлийнхнийг нийгмийн амьдралд хөлөө олоход нь туслах, энгийн мэргэжилд сургах, аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх тогтолцоо бүрдүүлэх талаар төр, засгийн хэмжээнд үр дүнтэй цогц шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Эрх зүйн хангалт нь албан хаагчийн эрх зүйн

хамгаалалыг хангаж буй цогц арга хэмжээний тогтолцоо бөгөөд олон улсын болон өөрийн орны хууль тогтоомжид заагдсан хүний эрхийн хэм хэмжээг үйл ажиллагааны удирдлага болгох, алба хаагчдын эрх зүй, түүний дотор нийгмийн хамгааллын орчинг боловсронгуй болгох, удирдах байгууллага, албан тушаалтан нарын эрх зүйн мөрдөлт, дэглэмийг сайжруулах, албан хаагчдын хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө, хөнгөлөлт, нийгмийн хамгааллын асуудлыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавихад хууль, хяналт, захиргааны байгууллагуудын ажлын уялдааг бэхжүүлэх, хуулийн хэрэгжилт, орчин, шаардлагын талаар судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах, байгаль, цаг агаарын янз бүрийн нөхцөл дэх хөдөлмөрийн стандартыг боловсронгуй болгох зэрэг болно.

Оюун санааны хангалт нь албан хаагчдын сэтгэл зүй, ёс суртахуун, үзэл санааны таатай нөхцөлийг хангаж буй цогц арга хэмжээний тогтолцоо бөгөөд хамт олны ёс суртахуун, сэтгэл зүйн байдалд тогтмол судалгаа, шинжилгээ явуулж, сэтгэл зүйн зохицсон тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлж, алба хаагчдын хоорондын зөрчлөөс сэрэмжилж, бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, ёс суртахууны тогтвортой байдлыг хангах, шинээр ажилд орсон, албан тушаалд анх удаа томилогдсон албан хаагчдад хамт олон, дарга нартайгаа хэвийн зөв харилцаа тогтооход нь сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, явдал юм.

Хөдөлмөр зохион байгуулалтын хангалт нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж буй цогц арга хэмжээний тогтолцоо юм.

Экологийн хангалт нь алба хаагчдын экологийн хамгааллыг хангаж буй, албаны үйл ажиллагаанаас хүн ард, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилготой цогц арга хэмжээний тогтолцоо юм.

Захиргааны хангалт нь цэргийн алба хаагчдын чанд сахилга, хувийн аюулгүй байдлыг хангах зорилготой цогц арга хэмжээний тогтолцоо бөгөөд хууль, журам, заавруудын заалтуудыг мөрдлөг болгон зохион байгуулах явдал юм.

Аюулгүй байдлын эмнэлгийн хангалт нь алба хаагчдын эрүүл мэндийн хамгааллыг хангаж буй цогц арга хэмжээний тогтолцоо бөгөөд ахуйн нөхцөлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагын түвшинд байлгах, хяналт явуулах, эрүүл мэндийн үзлэгийг үе шаттайгаар зохион байгуулах, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг судалж, тогтоох, шаардлагатай арга хэмжээ авах бүрэлдэхүүнийг эрүүл, мэндийн хяналтад хамруулж шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан чанартай илчлэг хоол хүнсээр бие бүрэлдэхүүнийг хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах, явдал юм.

Албан хаагчдын аюулгүй байдлыг хангах үйл